

З.Алтангэрэл - ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн 8032 дугаар дамжааны суралцагч, цагдаагийн дэд хурандаа

Ю.Бадамханд - Хууль сахиулахын удирдлагын академийн Цагдаагийн удирдлага, стратегийн профессорын багийн дэд профессор, хууль зүйн ухааны доктор (Ph.D). цагдаагийн хурандаа

ЦАГДААГИЙН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНЫ МАНЛАЙЛАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, ТҮҮНИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ЗАМ

“Эрх барих амархан, удирдах хэцүү”

И.В. Гёте

Хураангуй. Тус илтгэлээр манлайллын тухай ойлголт, түүний мөн чанар, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, цагдаагийн удирдах албан тушаалтны манлайлах чадварын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, улмаар түүнийг дээшлүүлэх арга замыг эрэлхийлэхийг зорьлоо.

Түлхүүр үг. Манлайлал, удирдлага, цагдаагийн албан, удирдах албан тушаалтан, ур чадвар, цагдаагийн алба

Аливаа байгууллагын үйл ажиллагааны амжилт, ололт зөв менежмент, сайн удирдагчаас шууд хамаарах ба энэ ч утгаараа удирдах албан тушаалтны манлайлалыг дээшлүүлэх, тэдний мэргэжлийн ёс зүйг төлөвшүүлэх нь хамгаас чухал бөгөөд энэ нь цаашдаа байгууллагын хөгжлийн гол үндсийн нэг болдог. Түүгээр ч зогсохгүй өнөөдөр "тогтвортой менежмент, шинэлэг, бүтээлч сэтгэлгээ байгууллагын хөгжил, дэвшилд амжилт авчрах гол эх үүсвэр болно" гэж үзэх болжээ.

Удирдах албан тушаалтны ур чадвар, удирдлагын арга барил, манлайллыг шинжлэх ухааны онолын үүднээс судлан тайлбарлах, улмаар түүний мөн чанарыг тодорхойлох, цаашлаад манлайлалыг бий болгох, хөгжүүлэх тухай асуудлыг авч үзэхийн тулд эхлээд “манлайлал” гэх ерөнхий ухагдахуун, ойлголтыг зөв танин мэдэх, ойлгохоос эхлэх учиртай.

Хэл бичгийн тайлбар толь бичигт: манлайлал (англ. leadership, орос. лидерство) - ажил үйлс, үг яриа, үйл хөдлөлөөрөө бусдад үлгэрлэх, тэднийг дагуулах үйлдэл’ гэж тайлбарлажээ.

Нийтийн соёл, танин мэдэхүйн талаас авч үзвэл:

Манлайлал - аливаа хүний бусдад нөлөөлөх чадвар ба өмнөө тавьсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хүсэл, тэмүүлэл төрүүлэх урлаг¹ гэж

¹ Б.Одбаатар. Байгууллагын удирдлага: онол, арга зүй. - УБ., 2015. 11 дахь тал.

тайлбарлажээ . Манлайллын эцсийн үр дүн бол удирдуулж байгаа хүмүүс зорилгодоо хүрэхийг хүсээд зогсохгүй, түүнд хатуу итгэл үнэмшилтэй, шаргуу тэмүүлж байх явдал юм.

Тэгвэл монгол хэлний үйл үгийн аймаг буюу үйл хөдлөл, биеэр гүйцэтгэх үйлдэл талаасаа "манлайлах" гэдэг нь: дагуулах, удирдах. чиглүүлэх. өмнө нь явах гэсэн үйл үгээр тайлбарлагдана.

Манлайлал нэг талаас хэн бүхэнд илэрхий ойлгомжтой мэт боловч түүний мөн чанарыг тал бүрээс нь бодитой тогтоох нь нарийн төвөгтэй ойлголт юм. Тийм ч учраас манлайлалыг дагнан судалсан нэрт эрдэмтдийн нэг Жэймс Мак Грегор Бернс "Манлайлал бол ертөнц дээр хамгийн их судлагдсан атлаа хамгийн бага ойлгогдсон ойлголт"² гэж дүгнэсэн байдаг.

Түүхийн эх сурвалжаас үзвэл дэлхий ертөнц дээр эрт үеэс манлайлал оршсоор ирсэн боловч "манлайлал" хэмээх нэр үг нь өөрөө нэлээн шинэ бөгөөд өргөн утгыг агуулж байдаг. 1933 онд хэвлэгдсэн англи хэлний Оксфордын толь бичигт "манлайлагч" буюу "лидер" хэмээх үг 1300-аад онд гарч ирсэн атал харин "манлайлал" буюу "leadership" хэмээх нэр үг XIX зууны эхэн үе хүртэл огт тэмдэглэгдээгүй байсан гэжээ.

Манлайлал хэмээх үг бусад хэлэнд тэр дундаа монгол хэлэнд ч саяхан болтол байгаагүй боловч гайхалтай нь энэхүү шинэ ойлголт нь урт ба богино хэлбэрийн, түүнчлэн шинжлэх ухааны үндэслэл бүхий болон практик үйл ажиллагааны хэрэглээ талаасаа маш олон тодорхойлолттой.

Үүнийг судлаачид ямар салбар, байгууллага дахь манлайлалын тухай авч үзэж байгаагаас хамааран манлайлалыг өөр өөр байр сууринаас тодорхойлж байгаа хэлбэр гэж үзэж ирсэн байна.

Манлайллын талаархи ойлголтын олон тодорхойлолтод зарим талаараа нийтлэг бас ялгаатай ойлголтууд ч байна гэж дүгнэн эдгээрийг нарийвчлан судлан дараах үндсэн чиглэлийн онолын ойлголт, тодорхойлолт байна гэж үзлээ. Үүнд:

□ Манлайлал - хүн сэтгэл зүй болон ур чадвар, түүнчлэн өөрт байгаа бусад нөөц боломжоо ашиглан бусдын сэдэл, урам зоригыг сэргээж, тэдний хүсэл зоригыг нь хангахад чиглэсэн үйлдэл ;

□ Манлайлал - бусдын зан үйлд нөлөө үзүүлэхийг оролдох үйл явц. Манлайлагч бол тодорхой эрх мэдлээр дамжуулан хүмүүст нөлөө үзүүлж, араасаа дагуулахыг оролддог хүн .

¹Удирдлагын социологийн нэр томъёоны тайлбар толь бичиг. Цахим эх сурвалж, холбоос: <https://gufo.me/dict/social> (орос хэл дээр).

²Burns. 1. Me. Leadership. New-York: Harper Colophon. 1978. p. 5. (англи хэл дээр).

Манлайлал - хүмүүсийн зорилгодоо хүрэх хүсэл, эрмэлзэл, үйлдлийг чиглүүлж, өдөөх авъяас чадвар .

Дээрхи ойлголт, онолын тодорхойлолтуудаас дүгнэхэд “манлайлал бол нэгдмэл зорилгын төлөө ажиллахад бусдад нөлөөлөх үйл явц”, өөрөөр хэлбэл, “бусдын зан үйлд нөлөөлөх үйл явц” гэж тодорхойлж болохоор байна. Монгол Улсад нийгмийн бүх салбар болон байгууллагын хогжилд мэдлэг чадвартай манлайлал чухал үүрэг гүйцэтгэх учиртайг бодлогын түвшинд ойлгож, түүнийг хөгжүүлэх талаар эрх зүйн баримт бичгүүдийг ч боловсруулан гаргаж, салбар бүрт хэрэгжүүлж, улмаар байгууллага бүр цаашдын хөгжлийн бодлого, стратегийг боловсруулахдаа үр дүнтэй манлайллын талаар тусгайлан авч үзэн удирдах албан тушаалтныг хөгжүүлэхэд анхаардаг болсон нь асар том дэвшил юм.

Гэвч төрийн албаны удирдах албан тушаалд мэргэжлийн ур чадвар, мэдлэг, оюуны чадвар, ажлын туршлагын шалгуураар томилогдох шударга ёсны тогтолцоо алдагдаж, "...намынх нь танилынх нь эсвэл ашиг сонирхлын зөрчилтэй хүмүүсийн цуглуулга болж хувирсан"¹ ба энэ нь төрийн албаны нэр хүндийг унагаж, улмаар алба хаагчдын албандаа хандах сэтгэлгээ, итгэл үнэмшлийг бууруулахад хүргэж байгаа асар том сөрөг үр дагавар болж байна.

Энэхүү гажуудал нэг өдөр бий болоод төрийн албыг бүхэлд нь хамраагүй бөгөөд сүүлийн 20 гаруй жил сонгуулиас сонгууль дамжин явагдаж байгаа энэ буруу тогтолцоог өөрчлөх, засах тухай хүн бүр ярьдаг, мэддэг.

Зарим баримт дурьдвал:

1. 2015 оны 6 дугаар сард АТГ-аар хянуулахаар 821 мэдүүлэг ирүүлсний 269 нь Цагдаагийн ерөнхий газарт хамааралтай байжээ. Энэ нь Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд дарга, дэд дарга нар 2015 оны 5 дугаар сард томилогдсоны дараах цаг үетэй холбогдож байна.^{1 2 3}
2. АТГ-ын 2017 оны 3-р улирлын тайланд: Цагдаагийн ерөнхий газар 350, Онцгой байдлын ерөнхий газар 71, Төрийн банк 62, Хил хамгаалах ерөнхий газар 50, Зэвсэгт хүчний жанжин штаб 46, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 43, Гадаад харилцааны яам 42 мэдүүлэг ирүүлсэн нь бусад байгууллагуудтай харьцуулахад өндөр байна.³ Энэ нь дээр нэр дурдсан салбар, байгууллагуудад

¹ “Том төрөөс ухаалаг төр лүү” Үндэсний зөвлөлдөх уулзалтын эмхэтгэл. УБ. 2013 он, т 31

²Авилгатай тэмцэх газрын мэдээлэл., 2015. Цахим эх сурвалж, холбоос:
<https://www.iaac.mn/news/2158>

³ Авилгатай тэмцэх газрын мэдээлэл., 2017. Цахим эх сурвалж, холбоос:
<http://www.iaac.mn/files/6e396b8e-a4cd>

2017 оны III улиралд хамгийн олон томилгоо, шилжилт хөдөлгөөн хийгдсэн гэсэн үг юм.

Иймд төрийн албаны удирдах албан тушаалд өндөр ур чадвартай, мэргэшсэн, дадлага, туршлагатай хүмүүсийг сонгон шалгаруулалтаар томилох, удирдагч, менежерүүдийг манлайлагч болгон төлөвшүүлэх. манлайлагчийн ур чадварыг системтэй хөгжүүлэх талаар олж авсан ололтоо улам бүр бататгаж сайжруулах. өндөр хөгжилтэй улс орнуудын туршлагаас байнга суралцах нь чухал болсон цаг үе иржээ гэж үзэж байна.

Цагдаагийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 4 дүгээр зүйлийн 4.1. дэх хэсэгт цагдаагийн байгууллагыг "Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн¹" гэж тодорхойлсон. Энэхүү чиг үүргээ амжилттай хэрэгжүүлэхэд иргэд, олон нийтийн дэмжлэг, туслалцаа, итгэл туйлаас чухал бөгөөд үүнийг нэг талаас цагдаагийн байгууллагын бүх шатны удирдах албан тушаалтны манлайлал, удирдах ур чадвараар дамжуулан олж авах учиртай.

Үүнээс улбаалаад "Цагдаагийн удирдах албан тушаалтны манлайлал ямар түвшинд байна вэ? гэдэг нь анхаарал татсан асуудал юм. Учир нь цагдаагийн зарим удирдах албан тушаалтан байгууллага, нэгжийг удирдах мэргэжлийн ёс зүйтэй, хамт олныг удирдах чадвартай, бүтээлч сэтгэлгээтэй, харилцааны өндөр ур чадвар, соёлтой байхад сайн жишээний хажуугаар саар зүйл байсаар байна.

Түүгээр ч зогсохгүй цагдаагийн удирдах албан тушаалтны манлайлал, ёс зүй, удирдлагын арга барилыг байнга дээшлүүлж, нийгэмтэй хөл нийлүүлэн алхахгүй бол хоцрогдсон үеийн дарангуйлж дээрэлхэх, дарамтлах аргаар удирдах нь нэгэнт амжилт олохгүй нь тодорхой. Иймд цагдаагийн удирдах албан тушаалтны манлайллыг дээшлүүлэх, түүнд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага зүй ёсоор бий болсоныг харуулж байна.

Цагдаагийн удирдах албан тушаалтны манлайллыг дээшлүүлэх тухай асуудал зөвхөн өнөөдөр магистрын судалгааны болон хүний нөөцийн бодлогын түвшинд яригдаж байгаа асуудал огт биш бөгөөд энэ нь цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтны ур чадварыг дээшлүүлэх бодлого, зорилго, зорилтын хүрээнд байнга анхаарлын төвд байсаар ирсэн билээ.

Тухайлбал 2013 онд Цагдаагийн ерөнхий газраас дэвшүүлсэн зорилтын 3 дахь заалт нь "Удирдах бүрэлдэхүүний манлайлал, удирдлагын

¹ Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/. 2017. Цахим эх сурвалж, холбоос: <http://www.legalinfo.mn/law/details/12469>

арга барил, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх", 2016 онд Цагдаагийн ерөнхий газраас дэвшүүлсэн зорилтын 1 дэх заалт нь "Удирдах ажилтны манлайллыг дээшлүүлж, алба хаагчид ажлын байрны зорилго, зорилтыг хангаж ажиллах" гэж орсон бол 2018 онд Цагдаагийн ерөнхий газраас дэвшүүлсэн зорилтод "Удирдах ажилтны манлайлал" -г хэвшүүлнэ гээд *Удирдах ажилтны манлайлал* - цагдаа дотоодын цэргийн анги. байгууллагын бүх шатны удирдах ажилтнууд менежментийн аргуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж. хууль дээдлэх Хөдөлмөрийн дотоод журам /код/ чанд мөрдөх, ажил хариуцах. хүнтэй харьцах. бусдыг хүндэтгэх, хүнлэг байх биеэ зөв авч явах зэргээр хамт олондоо биеэрээ, үйл ажиллагаагаараа үлгэрлэн дууриалал үзүүлэхийг ойлгоно гэж тайлбарласан байна.

Энэ нь цагдаагийн удирдах ажилтанд манлайлах ур чадвар зайлшгүй хэрэгтэй гэдгийг ЦЕГ-ын удирдлага ойлгож зорилт болгон дэвшүүлж ирснээр тайлбарлагдаж байна.

Удирдах албан тушаалтны манлайлал, удирдлагын арга барил, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх талаар тусгайлан зорилтыг дэвшүүлсэн нь сайшаалтай хэрэг боловч ЦЕГ-ын 2013 оны үйл ажиллагааны тайлангаас дүгнэхэд:

□ Цагдаагийн байгууллагаас шинэчлэлийн бодлогын хүрээнд зохион байгуулж буй ажил, арга хэмжээнүүд, Цагдаагийн ерөнхий газрын даргын үүргийн хэрэгжилт, түүний явц байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор "Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдах албан тушаалтнуудын сургалт, зөвлөгөөн"-ийг хоёр удаа зохион байгуулсан;

□ Гадаадын орнуудын туршлагыг судлах, тэдгээртэй хамтын ажиллагаагаа өргөжүүлэх талаар АНУ, Австрали, Голланд, Канад, Шинэ Зеланд, ХБНГУ, ОХУ, ОХУ-ын Бүгд Найрамдах Алтай болон Киргизстан Улс, Турк, БНХАУ, Вьетнам, Тайланд, Тайвань, Индонези улсад зохион байгуулагдсан сургалт, зөвлөгөөн, зөвлөлдөх уулзалт, удирдах ажилтны чуулга уулзалтад холбогдох чиглэл, мэргэжлийн болон удирдах ажилтан 76 алба хаагчийг томилон оролцуулав гэснээс өөр удирдах албан тушаалтны манлайлалыг дээшлүүлэхэд чиглэсэн тодорхой сургалт, арга хэмжээг авч явуулсан дорвитой ажил зохион байгуулаагүй байгаа нь тэдний манлайлах ур чадвар хэрхэн дээшилсэнийг үнэлэх дүгнэх боломжгүй байна. Харин цагдаагийн алба хаагчдын харилцааны ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр "Зөв харилцаанд суралцах". "Өөрчлөлтийг өөрөөсөө эхэлье". "Харилцааны ур чадварт суралцах нь" сэдвээр нийт 24 цагийн хичээлд 552 алба хаагчийг хамруулж, 4 цуврал зөвлөмж хүргүүлжээ.

2015 онд "Дэлхийн Зөн-Монгол" олон улсын байгууллагатай хамтран олон улсын хүүхдийн "Найрамдал" төвд "Удирдлагын манлайлал, ёс зүй" сэдвээр төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн тасаг, хэсгийн дарга нарыг хамруулсан сургалт зохион байгуулж, 45 удирдах албан тушаалтан хамрагджээ¹.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны 1 сарын 04-ний өдрийн Б/04 дүгээр тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу харьяа алба, нэгж, газар, хэлтсийн удирдах алба хаагчдын тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлага хангасан байдал, үйл ажиллагааны үр дүн, мэргэшил, ур чадварын түвшинг тогтоох шалгалтыг 2016 оны 1 сарын 08-22-ны өдрүүдэд зохион байгуулж, дүнг ЦЕГ-ын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэжээ. Мөн Улаанбаатар цагдаагийн хүрээний цагдаагийн газар, хэлтсийн хэрэг бүртгэх тасгийн 15 удирдах албан тушаалтанд "Удирдлагын менежмент" сэдвээр сургалтыг зохион явуулсан байна².

ЦЕГ-ын жил бүрийн үйл ажиллагааны тайлангаас дүгнэхэд жил бүр л цагдаагийн алба хаагчдын болон удирдах албан тушаалтны мэргэжлийн болон харилцааны ур чадвар, соёл, манлайллыг дээшлүүлэхэд чиглэсэн зорилтыг дэвпгүүлэн тодорхой ажлуудыг төлөвлөн зохион байгуулж байгаа хэдий ч бодит үр дүн гарахгүй л байна.

Цагдаагийн бүх шатны удирдах албан тушаалтан үйл ажиллагаандаа хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, нууцыг чанд хадгалах, олон нийтийн итгэл хүлээж бусдын дэмжлэгийг авах, багаар ажиллах, төрийн болон төрийн бус, нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэдтэй харилцан хамтран ажиллах, шинжлэх ухаан, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээний ололтыг бүтээлчээр ашиглах, нэгдмэл төвлөрсөн удирдлагын үндсэн зарчмыг удирдлага болгох нь энэ тэргүүний шаардлага юм. Түүнчлэн орчин цагийн удирдах албан тушаалтанд тавигдах үндсэн шалгуур, шаардлагад зүй ёсоор багтаж байгаа харилцааны ур чадвар, биеэ авч явах байдал, соёл, бусдыг хүндэтгэн эелдэг байх, эрсдэлийг давах туулах, нөхцөл байдлыг тал бүрээс бодитоор үнэлэн оновчтой шийдвэрийг цаг алдалгүй гаргах, манлайлах чадвар зэргийг эзэмшсэн байхыг нийгэм, цаг үе шаардаж байна.

Гэвч сүүлийн үед цагдаагийн зарим удирдах албан тушаалтны шударга бус үйл ажиллагаа, сахилга, ёс зүйн зөрчилтэй холбоотой иргэд, олон нийтийн шүүмжлэл байнга гарч байгаад дүгнэлт хийж, ажиллах нь чухал байна. Тухайлбал, цагдаагийн нэгж хариуцсан хэлтэс, тасгийн дарга нараас

¹ Цагдаагийн ерөнхий газрын 2013 оны үйл ажиллагааны тайлан.

² Цагдаагийн ерөнхий газрын 2015 оны үйл ажиллагааны тайлан.

2011 онд 5, 2012 онд 4, 2013 онд 2, 2015 онд 3, бүгд 14 алба хаагч гэмт хэрэгт холбогдсон¹ байгаа нь нийт гэмт хэрэг, шалгагдсан цагдаагийн алба хаагчдын 4,29 хувийг эзэлж байгаа нь бага бус үзүүлэлт гэж дүгнэж байна.

Түүнчлэн цагдаагийн байгууллагын "Хүний нөөцийн бодлогын баримт бичиг"-ийн 2.2 дахь хэсэгт "анхан болон дунд шатны удирдлагын менежмент сул, манлайлал дутагдалтай" гэж дүгнэсэн байгаагаас үзэхэд цагдаагийн шат шатны удирдах албан тушаалтны үүрэг хариуцлага, манлайллыг дээшлүүлэх, шаардлага бий болсон нь харагдаж байна.

Өнгөрсөн 2017 оны 12 сарын 06-ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагч, цагдаагийн хурандаа С.Баатаржав цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын удирдах албан тушаалтнуудтай цахим хурал хийж, дараах чиглэлээр үүрэг, даалгавар өгч, цаашид удирдах албан тушаалтанд өндөр шалгуур, шаардлага тавьж ажиллахаа мэдэгдсэн байна. Үүнд:

- хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд удирдах албан тушаалтан бүр идэвхи, санаачилгатай, ёс зүйтэй, **манлайлагч** байж, алба хаагчдадаа зөвхөн хууль ёсны шаардлага тавьж ажиллах;

- цагдаагийн эгнээ цэвэр, ариун байх ёстойг ямагт санаж, алба хаагч бүр өргөсөн тангарагтаа үнэнч, улс төр, бизнес, эрүүгийн бүлэглэлээс ангид байж, гагцхүү хуулийн хүрээнд шударгаар ажиллах;

- Мөн зарим нэгж, нутаг дэвсгэрийн байгууллагын удирдах албан тушаалтныг хоёрдмол санаа бодолгүй, зөвхөн төрийн ажлыг хэрхэн зөв авч явах, алба хаших хугацаандаа юуг санаачилж, сайжруулж болох талаар сэтгэл, хичээл зүтгэл гаргаж ажиллахыг онцгойлон сануулав. Ажил нь урсгалаараа явдаг, үр дүн гаргадаггүй, үгүйлэгддэггүй, царцанги байдалд орсон удирдах албан тушаалтан ч нилээд байгаад дүгнэлт хийж, үйл ажиллагаагаа сайжруулах талаар хатуухан үүрэг өгч, цаашид удирдах албан тушаалтны ажлыг дүгнэхдээ бодит шалгуур үзүүлэлтээр, чадамж, ажил хариуцаж байгаа байдал, алба хаагчдынх нь болон хариуцаж буй нутаг дэвсгэрийн иргэд, олон нийтийн санал хүсэлтийг харгалзан ажиллах талаар бодлого, чиглэл баримталж ажиллахаа мэдэгдсэн байна.

Мөн 2018 оны 01 дүгээр сарын 29-нд Цагдаа, дотоодын цэргийн удирдах ажилтны зөвөлгөөн дээр хэлсэн үгэндээ - "Ажлаа хийж чаддаг, чадаж байгаа хүнээ бид дэмжинэ. Харин хэн нэгнээр яриулаад, дэмжүүлээд, ажил хийхгүй албан тушаал аваад байдаг асуудлыг одоо зогсооно. Бид 2018 оныхоо зорилт руу чиглэн илүү ахицтай ажиллах ёстой. Өөрийгөө дарга гээд

¹ Мөн тэнд

бодчихсон ажлаа хийдэггүй. мэддэггүй хэнийг ч хэрхэвч ЗӨВШӨӨРӨХГҮЙ¹ гэж хэлсэн.

Судалгааны ажлын үр дүнг дээшлүүлэхийн тулд албан тушаалтны манлайлал цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үр дүн болон амжилтанд хэрхэн нөлөөлөх. удирдагчийн ур чадварт ямар байр суурь эзэлж болохыг тогтоох зорилгоор цагдаагийн удирдах албан тушаалтан болон алба хаагч. түүнчлэн иргэдийг оролцуулсан 196 хүний дунд "Та дараах өгөгдлөөс цагдаагийн байгууллагын амжилтад нөлөөлдөг хамгийн чухал гэсэн зүйлийг тодорхойлно уу?" гэсэн асуулга явууллаа.

Уг санал асуулгын дүнгээр:

1.	Удирдагчийн манлайлал	34 (17,34%)
2.	Багийн ажиллагаа, багаар ажиллах чадвар	28 (14,28%)
3.	Удирдагчийн мэргэжлийн ур чадвар	27 (13,77%)
4.	Хамт олны эв нэгдэл, нэгдмэл зорилго	25 (12,75%)
5.	Багийн гишүүдийн мэдлэг, боловсрол, ур чадвар	24 (12,23%)
6.	Байгууллага дахь харилцаа, соёл	22 (11,21%)
7.	Албаны сахилга хариуцлага	20 (10,20%)
8.	Үнэт зүйл, зорилгоо биелүүлэх хүсэл эрмэлзэл	16 (8,33%)

гэсэн үр дүн гарсан нь удирдах албан тушаалтны манлайлал цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнд ямар чухал үүрэг, оролцоотой болохыг нотолж буй хэрэг юм.

Мөн цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтны манлайлах чадварыг бодитоор судалж, түүнд үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор “Та өөрийн шууд удирдах албан тушаалтан буюу даргынхаа манлайлах ур чадварыг хэрхэн үнэлэх вэ?” гэсэн асуултаар 174 алба хаагчдын дунд санал асуулгыг явуулсан ба энэхүү санал, асуулгын дүнгээр 76 (43,67%) нь “сайн” гэж хариулсан бол, 51 (29,31%) нь “тодорхой үнэлж мэдэхгүй” гэж хариулжээ. Харин 35 (20,11%) нь “дунд буюу боломжийн түвшинд байдаг” гэж дүгнэсэн байхад, 12 (6,89%) нь “муу буюу манлайлах чадвар сул, хамт олныг удирдан ажиллах чадваргүй” гэж хариулсан байгаа нь мөн л анхаарал татах үзүүлэлт болж байна.

Дүгнэлт

Судалгааны үр дүнгээс харахад дараах дүгнэлтэнд хүрлээ. Үүнд:

1. Цагдаагийн удирдах албан тушаалтын манлайлал зөв, сайн байх нь нийт цагдаагийн бие бүрэлдэхүүнд нөлөөлөөд зогсохгүй нийгэм, ард иргэдийн дунд цагдаагийн байгууллагын нэр

¹ Цахим эх сурвалж, холбоос: <http://www.ontslokh.mn/131221.html>

хүндийг өргөх, иргэд, олон нийтийн цагдаад итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

2. Цагдаагийн удирдах албан тушаалтаны манлайллыг дээшлүүлэх тухай асуудал нэг жилийн дэвшүүлсэн зорилт төдийхнөөр биелэгдэх ажил огт биш бөгөөд энэ нь урт болон богино хугацааны сургалтаар дамжуулан тасралгүй зохион байгуулахад чиглэсэн цогц бодлого байна.
3. Удирдах албан тушаалтнууд алба хаагчидтайгаа ойр ажиллаж, тэдний сэтгэл зүйн байдлыг тандаж, идэвхжүүлэх, санал хүсэлт, тулгамдсан асуудлыг нь судалж, шийдвэрлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авах, холбогдох дээд шатны байгууллагад уламжлах зэргээр нийгмийн болон бусад баталгааг хангаж ажиллах шаардлагатай байна.
4. ХСИС-ийн Хууль сахиулах удирдлагын академид 2 жилийн хугацаанд удирдах ажилтан бэлдэж эхэлсэн нь сайшаалтай. Одоогийн сургалтын хэлбэр нь онолын хичээл давамгайл байна. ЦЕГ-тай нягт хамтран ажиллаж, тэдний санаа бодлыг тусган сургалтад бодит жишээ баримт дээр ажиллуулах хэлбэрийг түлхүү ашиглах нь суралцагчдын бие даан шийдвэр гаргах чадварыг түлхүү хөгжүүлэх юм.
5. Цагдаагийн удирдах албан тушаалтан бүрийн эзэмшвэл зохих зан чанар, удирдлагын арга барил, зарчим, манлайлах чадварын нийтлэг хэв загвар, шалгуур үзүүлэлтийг онолын үндэстэй тодорхойлж, улмаар түүнийг хүн бүрийн сэтгэл зүйн онцлогт тохируулан төлөвшүүлэх ерөнхий арга зүйг боловсруулан, түүгээр дамжуулан хүн бүрт нөлөөлөх арга замаар тэдний манлайлах чадварыг дээшлүүлэх нь онолын хувьд хамгийн зөв шийдэл гэж үзэж байна.